



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/64

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6, 4.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2024 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Батлан хамгаалах талаар туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний үр дүнг тайлагнах ажлаар аймагт болон "Хөвсгөл" цэргийн хүрээний анги, салбарт ажиллахад гарсан зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрхи 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ